

# ШИХИХУТУГ

Цуврал 34, Дугаар 1, 2026 оны 4 сар, хуудас 35-47  
[www.shu.edu.mn/journal](http://www.shu.edu.mn/journal)



## ШУДАРГА ЁС, ХИЧЭЭНГҮЙН СОЁЛ ТӨРИЙН ЭРХЭМСЭГ ОРШИХУЙН ҮНДЭС БОЛОХ НЬ

## JUSTICE AND DILIGENCE IN PUBLIC SERVICE CULTURE: FOUNDATIONS OF STATE DIGNITY AND ENDURANCE

Данзангийн Лүндээжанцан<sup>1</sup>

Shihutug University, E-mail: [lundeejantsan@shihutug.edu.mn](mailto:lundeejantsan@shihutug.edu.mn), <https://orcid.org/0009-0005-4588-9725>

### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

#### **Түлхүүр үгс:**

Монголын төр ёс, төррийн тогтолцоо, төррийн алба, төррийн албаны соёл, төррийн албаны зарчим: /шударга ёс, хууль дээдлэх, эе эвийн сэтгэлгээ/, төррийн албаны шинэчлэл

#### **Нийтлэлийн түүх:**

Хүлээн авсан: 2026, 03 сар  
Шинэчилсэн: 2023, 03 сар  
Хүлээн зөвшөөрсөн: 2023, 04 сар

#### **Keywords:**

statehood, public service culture, customs and traditions, justice, rule of law, state tradition, public administration reform.

#### **Article history:**

Received Dec, 2024  
Revised Feb, 2025  
Accepted Mar, 2025

### ХУРААНГУЙ

Энэхүү өгүүлэлд Монголын төр ёс, төрийн дэг жаягийн үүсэл хөгжил, түүний уламжлал ба шинэчлэлийн харилцан хамаарал, мөн төрийн албаны соёлын мөн чанар, агуулгыг судлан авч үзэв. Төрийн албаны соёлын үндэс болсон шударга ёс, эе эв, хариуцлага, хууль дээдлэх ёс зэрэг үнэт зүйл, зарчмуудын агуулга, ач холбогдлыг Монголын төрийн уламжлал, орчин үеийн төрийн албаны хөгжлийн хүрээнд шинжилсэн болно. Судалгааны үр дүнд төрийн албаны дэг жаяг, соёл нь төрийн байгууллын тогтвортой байдал, төрийн үйл ажиллагааны үр нөлөө, төрийн нэр хүндийг бэхжүүлэх чухал хүчин зүйл болохыг тодорхойлохыг зорив. Өгүүллийн шинэлэг тал нь төрийн албаны дэг жаяг, соёлыг Монголын төр, улсын бат бөх оршин тогтнохуй, төрийн эрхэмсэг чанарыг хадгалан хөгжүүлэх үнэт зүйлсийн нэгэн суурь үндэс хэмээн үзэж, түүний онолын болон практик ач холбогдлыг тодруулах оролдлого хийсэнд оршино.

This article examines the origins and development of Mongolian statehood, the formation of state customs and traditions, and the relationship between tradition and reform in the evolution of public administration. It further explores the nature and significance of public service culture, with particular emphasis on its fundamental values and principles, including justice, harmony, responsibility, and the rule of law. The study analyzes the role and importance of these values within the context of Mongolia's historical state tradition and contemporary public administration. The findings suggest that the customs, traditions, and culture of the civil service constitute essential factors in strengthening the stability, effectiveness, legitimacy, and prestige of the state. The novelty and significance of this article lie in its attempt to conceptualize public service customs and culture as one

<sup>1</sup> Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга

*of the fundamental pillars underpinning the continuity, resilience, and dignified existence of the Mongolian state, while highlighting their theoretical and practical relevance in the context of modern governance and public administration reform.*

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



## 1.Танилцуулга

Төрийн албаны соёл нь төрийн тогтвортой байдал, хууль дээдлэх ёс, иргэдийн төрд итгэх итгэл, үндэсний эв нэгдлийг хангах чухал хүчин зүйл болдог. Монголын төрт ёсны олон зуун жилийн уламжлалд шударга ёс, хичээнгүй зүтгэл, эе эвийн сэтгэлгээ, хууль дээдлэх ёс нь төр барихуйн үндсэн үнэт зүйл болон төлөвшиж ирсэн бөгөөд эдгээр нь төрийн албаны соёлын суурь агуулгыг бүрдүүлжээ. Өнөө үед төрийн албаны шинэчлэл, ёс зүй, хариуцлагын асуудал онцгой ач холбогдолтой болсон нөхцөлд энэхүү өв уламжлал, үнэт зүйлсийн мөн чанар, ач холбогдлыг судлах шаардлага улам бүр нэмэгдэж байна. Иймээс энэхүү өгүүлэлд Монголын төр ёс, төрийн албаны соёлын хөгжил, түүний суурь зарчмууд болох шударга ёс, хичээнгүй зүтгэл, хууль дээдлэх ёсны агуулга, ач холбогдлыг шинжлэн авч үзэж, эдгээр нь төрийн эрхэмсэг оршихуйн үндэс болохыг тодруулахыг зорив.

36

## 2. Арга зүй

Энэхүү судалгаанд Монголын төр ёс, төрийн албаны соёлын хөгжил, үнэт зүйлсийг шинжлэх зорилгоор түүхэн, харьцуулсан болон баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглан төрийн албаны дэг жаяг, соёлын агуулга, ач холбогдлыг судлав.

## 3.Судалгааны үр дүн

Төр ёс, Засаглахуйн арга ухаан хүн төрөлхтний нийгэмшин оршихуй, хууль цаазын сэтгэлгээний үнэт зүйл нь билээ. Энэхүү эрхэм үнэт зүйлийг бүтээхэд төрт ёсны 2000 гаруй жилийн түүхт нүүдэлчин удмын монголчуудын оруулсан хувь нэмэр үлэмж бөлгөө.

Монголын түүхийн эх сурвалжууд, эрдэмтэн мэргэдийн зохиол бүтээлээс үзэхэд, монголын төр ёсны сэтгэлгээ арга ухаанд хувь хүний авьяас билиг, ур чадвар, чин шударга хичээл зүтгэлд суурилсан төрийн удирдлага (өнөөгийн хэлээр ур чадвар, өсөлт хөгжилтөд суурилсан мерит зарчим), эрх, үүргийн нягт нямбай хуваарилалт, хариуцлагын тогтолцоо, хүн ардаа ялгаварлалгүй хандах шударга ёс, эе эвийн сэтгэлгээ, хууль дээдлэхүй, шашин, төрийн хэргийг хослон барих арга ухаан зэрэг

төрийн бодлого, үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндэс нь болсон зүйлүүд Монгол төр ёсны үнэт зүйл болон үеэс үед уламжлагдаж иржээ.

Монголын нүүдэлчдийн нийгэмд төр улсын холбогдолтой нэлээдгүй боловсорсон эртний уламжлал, түүхэн туршлага, мэдлэг чадвар хуримтлагдсан байсан бөгөөд тэр бүгд нь эцсийн бүлэгт Монгол Улс, Монголын эзэнт гүрний өвөрмөц уугуул хэв төрхийг бүрэлдүүлэн өгч, улс орны засаг төрийг өөрсдийн өвөрмөц арга барилаар хөтлөн явуулах бололцоог олгож байсан нь тодорхой. Чингис хаанаас ч өмнө нүүдэлчин малчдын дунд “хээр талын сэхээтний” үр хөврөл болсон бичгийн хүмүүс цөөнгүй байсан бөгөөд чухамхүү тэд л нүүдэлчин малчны амьдралынхаа зэрэгцээгээр эрдэм мэдлэгийн уламжлалыг тордон барьж нүүдэлчдийн хээр тал нутаг ба суурьшмал иргэншлийн ертөнц хоёрыг холбон зуучилж байсан ажээ”.

Монголын төрийн тогтолцооны тухайд Оросын академич В.В.Бартольд “... хэдийгээр дутагдалтай ч гэсэн урьд өмнө оршиж байсан төрийн тогтолцоонуудтай харьцуулбал оновчтой, маш хүчтэй зохион байгуулалт бүхий төрийг тогтоож байсан болой. Энэ нь Монголын эзэнт улсын бүрэлдэхүүнд орсон бүх мужид сүрхий нөлөө үзүүлж байв”<sup>2</sup> гэжээ. Чингис хааны байгуулсан төр агуулга, хэлбэрийн хувьд өөрийг нь таалал төгссөнөөс хойш 150 жилийн турш оршин тогтнож эзэнт гүрний олон үндэс, язгуур угсаатны иргэд, харьяат нартаа “Төр бол эрхэмсэг байдаг”-ийг ойлгуулж чадсан нь нэрт эрдэмтний үнэлгээ үндэстэй болохыг нотолж байна. Их Монгол Улсын төр ийнхүү хүч нөлөөтэй эрхэмсэг оршиж байсны уг сурвалж нь төрийн хүмүүний шударга хичээнгүй хичээл зүтгэл, ур чадвар, туршлагыг эрхэмлэсэн төр ёсны үзэл баримтлалыг хэлбэрэлтгүй сахиж байсныг түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн хэлбэртэлгүй сахиж байсныг түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлджээ. Тухайлбал, Рашпунцагийн “Болор эрх” зохиолд төр ёсны үзлийг агуулгын хувьд хэрхэн тодорхойлсныг дурдвал:

- Төрийн албанд шударга сайн хүнийг сонгож ажиллуулах,
- Төрийн албыг цомхон байлгах,
- Улсын санг арвилах, иргэдээс татварлан авах зүйлийг хэмжээтэй байлгах,
- Төрийн хүний хариуцлагыг өндөр байлгах,
- Төрийн эрх мэдлийг болгоомжтой хэрэглэх,
- Иргэдийн сэтгэлийг олж өршөөлөөр заах зэрэг болно .Өгөөдэй, Хубилай сэцэн хаан нар “Чингис хаан морин дэл дээр байгуулсан улсыг мориноос буулгүй удирдаж болохгүй гэж зөвлөснөөр мэргэн сайд Елюй Чу-Цайн зөвлөмж<sup>3</sup>-ийг иш үндэс болгон улсыг байгуулахдаа ширүүн аргаар байгуулсан одоо улсыг тогтоож хөгжүүлэхэд ширүүн байж болохгүй, харин зөөлөн байх хэрэгтэй хэмээн сургаж өөрийн хаан суурийг тавьж өгснийг хатуу баримталж байжээ.”

<sup>2</sup> Бартольд В.В. Сочинения Т, Т., 1963, т.719

<sup>3</sup> Жүгдэр Ч. Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ., 1990, т.38.

Энэхүү бодлогын утга учир нь “Хаан” эцгийн зовж байгуулсан улсыг бүү зовооё, хаан эцгийн бэлхэн суурийг эзлээд иргэнийг үл зовоохыг эрхэм болгоё<sup>4</sup> (Өгөдэй хаан) зэрэг сургамж захиасны зүйлүүдэд болон Хубилай хааны төр, шашин хоёрыг хослон явуулах, эрдэм чадал, ур чадвартай, шударга түшмэлийг түших арга ухаан, иргэдээ соён гэгээрүүлэх, хуулиар засаглах арга ухаанаар тодорч байжээ.

Хубилай хаанаас эхлэн төрийн албанд хүмүүсээс шалгалт авч оруулдаг журам тогтжээ.

Монголын төр ёсны үнэт зүйлс болох шударга ёс, „хичээл зүтгэлээ эвийн сэтгэлгээ зэрэг нь төрийн бодлого, үйл ажиллагааны ёс суртахууны үндэс нь болж байсан. Чингис хаан:

Алд бие минь алжааваас алжаатугай

Ахуй төр минь бүү алдартугай

Бүрэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай хэмээн төрд зүтгэхийн утга учрыг тайлан сургажээ

Английн түүхч, зохиолч, аялагч Жон Мэн: “Тэр бээр байлдан дагуулалтаасаа хэмжээлшгүй их ашиг олох боломжтой байсан хэдий ч энэ боломжоо ямар ч л байсан хувийнхаа зорилгод ашиглаагүй байдаг юм. Чингис хаан авлига, хээл хахуульд өртөөгүй, харин нээлттэй, өгөөмөр хүн байсан бөгөөд тэрээр зоригжуулан зохион байгуулагч, юм юмыг сонирхон мэдэхийг хүсэгч итгүүлэгч гээд олон олон сайн чанарын эзэн байжээ.”<sup>5</sup> гэсэн байна.

Жак Уэтерфорд Чингисийн төрийн шударга ёсны тухай: “Ихэнх захирагч өөрсдийгөө хуулиас дээгүүр тавьдаг бол Чингис хаан ихэс дээдэс, дорд малчныг ч хуулийн өмнө адил тэгш хариуцлага хүлээхийг шаарддаг байлаа. Ямар ч шашинтан байсан шударга ёсыг нийтээр дагаж мөрдөхийг харьяат албатдаа шаарддаг, тэр эзэмшил нутагтаа шүтэн бишрэх эрх чөлөөг бүрэн хангасан юм. Тэр ихэс дээдсийн хэргэм зэрэг, эрх ямба, угсаа гарвал гэх мэт хуучин тогтолцоог халж, хувь хүний гавьяа зүтгэл, үнэнч шударга байдал, ололт амжилтад тулгуурладаг шинэ тогтолцоог бий болгосон юм”<sup>6</sup> гэжээ.

Чингис хааны үед хахуулиар, шударга бус үйлээр албан тушаал, эрх мэдэл, гавьяа шагналд хүрч байсангүй. Байгуулсан гавьяа, шударга хичээл зүтгэл, эрдэм ухаан, ёс суртахуун ы чанараар нь хүнийг албан тушаалд томилж, шагнан урамшуулж байжээ. Германы эрдэмтэн Удо.Б.Баркман “сонирхолтой нь Чингис хааны цусан төрлийнхөн удирдах албан тушаал бараг хашиж байсангүй. Тэгэхлээр орчин үеийн боловсон хүчний бодлогод ч Чингис хаанаас суралцууштай” гэж бичжээ<sup>7</sup>.

---

<sup>4</sup> Цанжид А. Төр барихуй монгол ухаан, УБ., 2011. т.101.

<sup>5</sup> Мэн Ж. Чингис хааны манлайллын нууц. Орчуулагч даизэвэг Ц. УБ., 2012, т.31.

<sup>6</sup> Жак Уэтерфорд. Өнөөгийн ертөнцийг үндэслэгч эзэн Чингис хаан. УБ., 2012, т.102.

<sup>7</sup> Удо.Б.Баркман. Чингис хааны үед төр цэргийн элит давхарга болж хөгжсөн нь, Монголын түүх, улс төрийн тухай өгүүллэгүүд. УБ., 2012, т.432.

Мөн монголын түүхийн эх сурвалж: Монголын Нууц Товчоо, “Сударын чуулган” зэргээс үзэхэд Мөнх тэнгэрийн хүчний үзэл санаа, шударга ёс, эе эвийн сэтгэлгээ, сэтгэл хоёрдолгүй хичээнгүйлэн зүтгэх хүсэл эрмэлзэл, ур чадварт суурилсан соёл нь монгол төрийн бодлогын ноён нуруу, амин сүнс нь байв. Үеэс үед уламжлагдах энэхүү үнэт зүйл нь болж Их Монгол Улс байгуулагдан дэлхийн хөгжлийн бодлогыг тодорхойлогч их гүрэн болсны нэгэн нууц увдис нь монгол төрийн бодлогын эдгээр үнэт зүйлсийн дотно, гаднын түмэн олныг өөртөө татах, эвлэлдүүлэн нэгтгэх их хүчин байжээ.

Жувейни: “Тэдний монголчуудын шударга хичээнгүй байдлыг хэлбэл гайхалтай хэмжээнд хүрчээ. Арван түмэн цэргийг ерөнхийлөн захирдаг жанжин байлаа ч хамаагүй, хэрэв алдаа, осол гаргасан байвал хаанаасаа хэдий хол алслагдсан ч байг, хаан нь морьт хуягаасаа ганцханыг илгээвэл даруй тогтсон арга хэлбэрээр өнөөхийг нь шийтгэж чадна. Жишээлбэл, толгойг нь авна гэсэн бол толгойг нь огтолно. Алтыг нь авна гэсэн бол биеэс нь алтыг авч одно” гэх зэргээр бичжээ<sup>8</sup>.

Шударга ёсыг монгол гэрийн тоонотой адилтгаж болно. Тооногүй монгол гэр байдаггүйтэй нэгэн адил аливаа хүнд авьяас билиг байгаад ч шулуун шударга, ариун явдалгүй бол хүний мөс чанараа алдана. Шударга ёс алдагдвал улс орон ч өөдлөн дэвжихгүй. Чингис хаан шударга удирдлага бүхий засаг төрийг цогцлоосон<sup>9</sup>. Энэ тухайд Чингис хаан хутагт арш Чанчунь бөмбод илгээсэн захидалдаа улс орондоо чин сэтгэлээр чигч шударгыг эрхэмлэн тогтоолоо. (Чанчунь бөмбө өрнө этгээдэд зорчсон тэмдэглэлд)<sup>10</sup> хэмээн бичсэн байна.

Чингис хааны төрийг үзэх үзэл, түүний ёс суртахууны чөмөг нь болсон шударга ёсны үзэл баримтлалд түүний залгамжлагчид, үр ач нарын үед уламжлагдан хөгжиж байсныг түүхийн сурвалжууд нотолдог байна. Их хаад Их хаан хүмүүн заавал шударга, өгөөмөр, эе эвийг хичээдэг, тулхтай болж өгвөл тийм байх ёстой гэсэн итгэл, үнэмшилтэй байжээ.

Ч.Жүгдэр аругай “Өгөдэй Их хаан эцгийн сургаалыг хэлбэрэлтгүй дагаж шударга ёс, эрдэм боловсролтой бичиг номын хүмүүсийг эрхэмлэх бодлого барьж байсан”-ыг онцолсон нь бий<sup>11</sup>.

Монгол төрийн эрхэм үнэт зүйл болсон төрийн албаны соёл нь албандаа сэтгэл хоёрдолгүй, үнэнч шударгаар хичээнгүйлэн зүтгэх хүсэл эрмэлзэл, бичиг номын мэдлэг, боловсрол, харилцааны соёл, арга ухаан, цаг үеийн торгон мэдрэмж, төрийн хууль тогтоомжийг ойлгон ухаарах, хэрэглэх ур чадварын цогц буюу төрийн байгууллага,

<sup>8</sup> Жувейни Ала-Ад Дин Ата-Мелик. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. УБ., 2006, т.113.

<sup>9</sup> Нарангэрэл С. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастшир. УБ., 2014. т.31.

<sup>10</sup> Ли Жичан. Чанчунь бөмбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл. Орчуулагч Гангабаатар Я. Ганбаатар Ц. УБ., 2010, т.14.

<sup>11</sup> Жүгдэр Ч. Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., 2006, т.128.

түүний албан тушаалтны үйл ажиллагааны арга юм. Энэ тухайд академич Ж.Болдбаатар “Төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны ажлыг удирдах, зохион байгуулах, гүйцэтгэх эрх, эрх мэдлээ албан тушаалтан хэрхэн яаж хэрэгжүүлэх арга ухаан, мэдлэг чадвар, дадал туршлагын цогц юм” (Ж.Болдбаатар, Монгол төрийн албаны соёлын уламжлал, шинэчлэлийн асуудал. Шихихутуг сэтгүүл ..... 4-6 дахь талд) гэсэн бол судлаач Д.Зүмбэрэлхам “Төрийн албаны соёл нь бүх шатны төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны соёлоор дамжин илэрдэг, түүнээс бүрэлдэн тогтдог, түүгээр хэмжигддэг, тодорхойлогддог нь ойлгогдохоор байна” гэжээ.

Монголын төр ёс, төрийн албаны соёлын мөн чанар нь “Төрийн хэрэг бага ч гэсэн их, гэрийн хэрэг том ч гэсэн бага”, “төр төмбөгөр, ёс ёмбогор” гэсэн ардын мэргэн ухаанаар илэрхийлэгддэг гэж хэлж болно.

Дээр дурснаас үзэхэд төрийн албаны соёлын үндсэн зүйлүүдэд:

- Төр, түүний байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, чиг үүрэг (эрх мэдэл) зөвхөн хуулийн хүрээнд байж хуулиар зохицуулагдсан байх,
- Төрийн түшээ, албан тушаалтан бүрд хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг эрхэмлэн сахих ухаарал, мэдрэмж, харилцааны соёл тогтсон байх,
- Мэргэжлийн ур чадвар, цаг үеийн мэдрэмж, асуудал, зорилтын гол гогцоог олж харах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, хэрэглэх, хэрэгжүүлэх чадвар зэргийг хамааруулж болно гэж үзэж байна.

Энэ ерөнхий агуулгаар нь авч үзвэл манай төрийн бүх байгууллага, тэдгээрийн албан хаагчдын ажил, үйлчилгээнд Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд болох “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх ёс”<sup>12</sup> хэр зэрэг хэрэгжиж байгаагаар төрийн албаны соёлын түвшин хэмжигдэнэ гэж үзэж болох юм. Энэ бүхнээс үзэхэд төрийн албаны соёлын ноён нуруу нь мэргэжлийн мэдлэг ур чадвар, үнэнч шударга хичээл зүтгэл гэж үзэж болно. Тиймээс ч монгол төрийн албаны соёлыг "хичээнгүйн" хэмээн авгайлах бөлгөө.

Монголын төр улсын бүх үеийн хууль эрхийн баримт бичгүүдэд, тухайлбал: Их Монгол Улс, Юань гүрний хууль цаазын бичиг (1264 он), “Ертөнцийг засах магад хууль” буюу “Хаан төрийн ертөнцийг засах магад хууль” (1312 он), “Их Юанийн нэвтэрхий хууль” (1322 он), Улс төрийн бутралын гэж нэршигдсэн (ойролцоогоор 1370-1660-аад он) үеийн “Монгол-Ойрадын хууль” (1640 он), “Алтан хааны цаазын бичиг”, манжийн ноёрхлын үеийн “Халх журам” (1709-1795 оны хооронд зохиогдон мөрдөгдөж байсан), “Гадаад Монголын хууль зүйлийн бичиг” (1785 он), Олноо өргөгдсөн Монгол Улсын (Богд хаант Монгол Улсын үеийн) “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” (1915-1918 он) зэрэг төрийн хууль цаазын эх сурвалжид түүхэн тодорхой байр

---

<sup>12</sup> Мөн тэнд. т.15.

сууринаас харьцуулсан судалгаа хийж үзвээс Монгол төрийн хууль цааз, төр засах үндэсний ухамсар, сэтгэлгээний уламжлал болж хадгалагдсан үнэт зүйлсэд:

1. Нийт иргэндээ эрх ямба, эд хөрөнгө, угсаа гарвалиас нь үл хамааран алагчлалгүй, тэгш шударга, нигүүлсэнгүй хандах шударга ёсны суртахуун байсан. Энэ бол төр барихуйн ертөнц даяар хүлээн зөвшөөрөгдөж гайхагдсан арга ухаан байжээ. Академич С.Нарангэрэлийн бичсэнээр Монгол төрийн хууль цаазын хамгийн эрхэм нандин уламжлал, ой санамжийн үнэт зүйл нь шударга ёсны ёс суртахуун болж иржээ.

2. Хууль цааз, зарлигаар тогтоосон дэг журмыг хэлбэрэлтгүй сахих, сахиулах (өнөөгийн хэллэгээр хуулийг дээдлэн сахих) ухамсар сэтгэлгээ, дэг жаягийг тогтоосон. Тухайлбал, “Ноёд түшмэд, цэрэг дайчид, хөтөч зарц хүртэл тус тусын тушаалаа гүйцэтгэн чадваас мөнх Тэнгэрийн хүчинд их үйлс бүтээх ажгуу. Гиймээс миний сургаалыг мянган онд хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлатугай”. Эдгээр (1, 2) нь шударга ёс, ёс суртахуунтай салшгүй холбоотой, хэрэгжих нөхцөл, хэлбэр нь болсон шаардлагууд юм.

3. Байгаль эх, уул усаа “амилуулан шүтэж”, хайрлан хамгаалах үзэл санааг зарчмын зүйлүүд, хүмүүний зан заншил, дэг жаяг болтол суулгаж өгсөн. Тухайлбал, Их засаг хуулийн бүрдэлд орж буй Чингис хааны зарлигт “Хөрс шороог галдаж өвс бэлчээрийг хохируулахыг хориглоно” гэж заажээ. Бүр XIII зууны эхэнд хуулийн ийм хэмжээ тогтоон мөрдөж байсныг өнөө Монгол оронд төдийгүй дэлхий нийтэд байгаль орчны хурц асуудал болоод байгаа “Цөлжилттэй тэмцэх” гэж томьёологдсон олон улсын анхаарал татсан асуудлыг хууль эрх зүйн анхны үндэс Монгол улсад тавигдаж байжээ гэхэд бодит байдлаас хол зөрөхгүй<sup>13</sup>. Байгаль эхээ хайрлан хамгаалах ухаарал мэдрэмж нь монгол төрийн албан хаагчдын эрхэм чанарт ёс зүйн хөдөлшгүй хэм хэмжээ нь болж ирсэн зүйл юм.

4. Монголын түүхийн бүх цаг үеийн хууль цаазын эх сурвалжуудад Монгол төрийн удирдлагын нэгдмэл байдал, эе эвийг хичээх зэрэг төр ёсны тулгуур зарчмуудын тухай заалтууд цөөнгүй байдаг. Тухайлбал, “Сударын Чуулган”-нд тэмдэглэж үлдэсэнээр “Чингис хаан айлтгаруун: Ард түмний дунд хүүхдүүд нь эцэг өвгөдийнхөө сургаалыг эрхэмлэдэггүй, дүү нар нь ах нарынхаа үгийг үгэнд анхааран ханддаггүй, эр нөхөр нь эхнэртээ итгэдэггүй, ахмад хүмүүс нь багачуудаа хайрладаггүй, багачууд нь ахмадуудынхаа сургаалыг хүлээн авдаггүй, ихэс дээдчүүд нь өөрийнхөө шадар түшмэд нөхдөөсөө бусдын сэтгэл зүрхийг өөртөө татахыг боддоггүй, эд баялаг эрхэм бүхнийг эзэмшин, ашиглаж байдаг эрхэм хүмүүс улс орныхоо хүмүүсийг баяжуулан, тэтгэн дэмждэггүй, ёс заншил, засаг хуулийг ухамсарлан тоомсорлодоггүй шалтгаанаар хулгайч, худалч (бүхий л) луйварчин, дээрэмчид төр баригчдад тэрслэн, айл өрхөд туслах гэгээн нарыг сүүдэртүүлнэ” хэмээн сургамжилжээ.

Төрийн албаны соёлын нэгэн тулгын чулуу нь төрийн хүмүүний хүмүүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих, угсаа гарвал, яс үндэс, нас хүйс, ертөнцийг үзэхүй, эд

<sup>13</sup> Амархүү О. Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. УБ., 2022, т.55-60.

хөрөнгө зэргээс нь үл хамааран тэгш шударга хандах ухамсар мэдрэмж, улс үндэстнийхээ эе эвийг сахих ухамсар мэдрэмж, хандлага нь болж иржээ

Эе эвийн сэтгэлгээг зөвхөн үндэстэн, ястны хоорондын харилцаанд төдийгүй ертөнцийг үзэхүй, итгэл үнэмшлийн ялгаа зааг, улс төрийн олон ургалч үзэл бодол, өөр өөр ашиг сонирхол зэрэгцэн орших, өрсөлдөх (уралдах) болсон үед орон гэр болсон улс үндэстнийхээ нийтлэг ашиг сонирхлыг ухаарч ойлгох, үйлдэл, үйл ажиллагаагаа түүнд нийцүүлэх, бусдын ашиг сонирхол, хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэж сахих арга ухаан гэж ойлгох учиртай.

Эдүгээ Монгол төрийн бодлого, үйл ажиллагааны үнэт зүйлсээс нэн чухал нь хууль дээдлэх ёс юм. Үүнийг Үндсэн хуулийн эхийг баригч, нэрт хуульч Б.Чимэд дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

- Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах харилцааг хуулиар, хууль тогтоомжийн актаар зохицуулах,
- Аливаа хууль, эрх зүйн актууд төрийн гол хуульд нийцсэн байх,
- Улсын гол хууль, түүнд нийцсэн хууль тогтоомжийг улс даяар нэг мөр ойлгож, нийтээр дагаж мөрдөх,
- Хүний эрх, эрх чөлөө нь хуулиар баталгаажих, шударга шүүхээр хамгаалагдсан байх,
- Хууль зөрчсөн гэм буруутай хэн боловч хууль зүйн зохих хариуцлага хүлээх.

Б.Чимид абугай: “хууль дээдлэх ёсон бол засаг төр барих урлаг, Хүн зон амар жимэр амьдрахуйн арга юм”<sup>14</sup> гэсэн билээ.

---оОо---

---

<sup>14</sup> Чимид Б. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ., 2006, т.150.

Монгол төрийн бодлого, үйл ажиллагааны дээр дурдсан үзэл санаа, үндсэн зарчим нь төрийн хууль цаазын өнгөрсөн, одоо, ирээдүй гурван үеийн нийтлэг чиг хандлага нь болж иржээ. Тухайлбал, Монгол төрийн хууль цаазын сэтгэлгээний эх сурвалжууд, тухайлбал: болох Их Засаг хууль, Богд хаант төрийн хууль зүйн гол баримт бичиг Монгол улсын хууль зүйн бичиг зэрэгт эдгээр үзэл санаа шингэсэн байдаг/шигтгээ 1,2,3-ыг үзнэ үзнэ үү/

#### **Шигтгээ-1**

*Их Монгол улсын төрийн хууль цааз, эрх зүйн гол эх сурвалж нь болсон “Их Засаг” хуулиар төрийн хэлбэр, дэглэм, хааны эрх мэдэл, төрийн байгууллагын зохион байгуулалт, эрх, үүрэг, ажиллах журам, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, эзэн албатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах ба эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоожээ. Тухайлбал, Их Засагт гадаад харилцааны цааз, цэргийн цааз, шүүх, шашны цааз зэргийг бүхэлд нь “Төр засах цааз”-д, харин ахуй заншил, иргэд хоорондын харилцаа, сургаал сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв залгамжлал, гэрлэлт, гэр бүл, арилжаа худалдааны шинжтэй хэм хэмжээнүүдийг “Иргэний аж байдлын цааз”-д хамруулснаас гадна Их Монгол Улсын төрийн бүрэн эрх, нийгэм төрийн байгууламжийг бэхжүүлэх, түүнчлэн хуулиар тогтоосон бүх хэв журмыг гэмт халдлагаас хамгаалах “Эрүүгийн цааз”-ыг тодорхойлон тогтоосон, өөрөөр хэлбэл, нийгмийн харилцааг бүхэлд нь эрх зүйн зохицуулалтад оруулжээ.*

43

#### **Шигтгээ-2**

*ХЗБ (Монгол Улсын хууль зүйлийн бичиг)-ийн нэгдүгээр дэвтэрт Олноо өргөгдсөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг, хоёрдугаар дэвтэрт төрийн яамдад ажиллах албан хаагчийн орон тоог хуульчилсан бол гуравдугаар дэвтэрт яамдын зохион байгуулалт хийгээд эрх зүйн байдлыг, дөрөв, тавдугаар дэвтэрт хэргэм зэрэг залгамжлах ёсыг хуульчлан тодорхойлжээ. Тухайлбал, ДХБЗШЯ-ны тэргүүн сайд 1, дэд сайд 2, дус түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1, эх бичиг зохиогч түшмэл 6, эх зохиогч түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1, жинхэнэ бичээч 12, нярав 1, хаалганы дарга 1, зарлага 5, хаалга сахигч 4, галч 4, нийт 38 хүний орон тоотой бол ГХБЭШЯ-нд тэргүүн сайд 1, дэд сайд 2, эрхэлсэн түшмэл 1, дэс түшмэл 2, эх бичиг зохиогч түшмэл 6, жинхэнэ бичээч 10, орос үсэг орчуулагч түшмэл 1, бичээч 1, хэлмэрч 1, хятад үсэг орчуулагч түшмэл 1, бичээч 1, хэлмэрч 1, нярав 1, хаалганы дарга 1, зарлага 4, хаалга сахигч, галч 4, нийт 42. Энэ мэтчилэн бусад яамд болох ЦХБЗШЯ 50, СХХБЗШЯ 42, ШТХБЗШЯ 57, Улсын хурлын яам 11 гэх мэт яам тус бүрийн эрхлэх ажил үүргийн онцлогоос шалтгаалан орон тоо, бүтцийг өөр өөрөөр тогтоосон. Монгол Улсын засгийн газар нь Дотоод яам, Гадаад яам, Цэргийн яам, Сангийн яам, Шүүх яам, Улсын хурлын яамнаас бүрдэж байсны гадна Улиастай, Ховд, Хиагтад аймаг хошуудын хэрэг хамааран шийтгэх сайдын газар ажиллах болсон байна. Өмнө дурдсан яамдын тэргүүн, дэд тэргүүн, дэд сайдууд нь тус тусын яамны бүх хэргийг эрхлэн захирч, Засгийн газрыг бодлогыг тодорхойлж, өдөр тутмынх нь үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэйн дээр эрхэлсэн түшмэл, дэс түшмэлүүд нь тус тусын яамны хэлтсүүдийг удирдан бүх ажлаа сайдын өмнө хариуцна. Ийнхүү ХЗБ-т төрийн яамд, тэдгээрийн эрх, үүрэг, ажиллах орон тоог тогтоожээ.*

### Шигтгээ-3

ХЗБ-т анхаарал татах асуудалд төрийн түшмэдийг сонгон шалгаруулах, шалган байцаах заалтууд байна. Түшмэл хүний үл тэвчих зүйлд ховдог, харгис, зөөлөн үхээни, чадалгүй, хичээнгүй бус, өвчтэй, долги хатан, эрдэм дорой явдал хэмээн тодорхойлжээ. Ийнхүү тухайн орон тоонд дурдсан шалгуураар шалган хэлэлцэж, дэвшүүлэх, бууруулах эсэхийг шийднэ. Энэ нь тухайн үед монгол төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж авахдаа юун түрүүнд тухайн албан тушаалд таарч тохирох эрдэм мэдлэг, сахилга бат, ажил байдлын тодорхойлолт, нас, ёс суртахуун зэргийг харгалзах болсон явдал нь түүний дэвшилттэй талыг харуулаад зогсохгүй тус ХЗБ-ийг манжийн хуулийн хуулбар биш гэдгийг нотлох бас нэгэн баталгаа гэж хэлж болно. Тухайлбал, тус хуульд ... Чухам шалгах нь дөрвөн зүйл, эрдэм, сахилга, хэрэг, насыг бодно гэж монгол төрийн албанд түшмэлийг сонгон шалгаруулахдаа дурдсан дөрвөн зүйлийг заавал харгалзан үзэх шалгуур болгосон байдаг. Тэгвэл Манжийн төрийн үед түшмэдийг сонгохдоо гол төлөв эзэн хаандаа үнэнч эсэхийг гол шалгуур болгож байсныг цөөнгүй судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн нь бий. Эндээс монгол төрийн албанд түшмэл хүн 1. Эрдэм боловсролтой, төрийн бодлогыг уламжлал, шинэчлэлийг хослуулан хэрэглэх чадвартай, 2. Иргэний хийгээд төрийн ёс журмыг санд сахин ажилладаг, өргөсөн тангарагтаа үнэнч, 3. Төрийн хэрэгт хариуцлагатай, ажил хэрэгч, тууштай, 4. Нас идэр, тэнхлүүн хийгээд туршилагатай, энэ бүгд цөм бүрдэж төрийн хэрэгт зүтгэх ажээ. Мөн ашигт малтмалын талаар нэлээд нухацтай анхаарч байсныг ч энэ дэвтрийн заалтаас харж болно. Тодруулбал, эл дэвтрийн аливаа алт ба мөнгөний зэргийн орд элсийг хулгаж эрхийг байцаахыг алдсаныг яллах нь гэсэн зүйлд ашигт малтмалын ордыг зохих зөвшөөрөлгүйгээр хэнд ч ашиглуулж болохгүй бөгөөд хэрэв зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг нэлээд хатуу заасан байна. Тухайлбал, монголын харьяат хүн дээрх заалтыг зөрчвөл тухайн аймгийн чуулган даргын буюу шавийн шанзудбад хүргүүлж зохих шийтгэл ногдуулах бөгөөд харин гадаадын иргэд монгол нутагт зөвшөөрөлгүйгээр үнэт металлын орд эрж хайвал Гадаад яаманд шилжүүлж, хэргийг шийдвэрлүүлж байхаар тогтсоноос гадна энэ талын хэрэг өдүүлсэн гэм буруутныг илрүүлж чадаагүй буюу алдаж зугтаалгасанэ түшмэдийг нэг есөн мал торгохоос эхлээд зуун ташуур занчих, уул албан тушаалаас нь огцруулах хүртэл шийтгэл ногдуулдаг байв. Улмаар харьяат хошууныхаа түшмэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж чадаагүйгээс болж алт мөнгө зэрэг үнэт металлын ордыг зөвшөөрөлгүй эрж хайсан гэм буруутныг илрүүлж чадаагүй буюу оргуулж алдсан засаг ноёдын пүнлүүг хоёр жилийн хугацаагаар хасахыг заажээ. Энэ бол монголын төр газар нутаг, хүрээлэн буй орчноо хамгаалах талаар онцгой анхаарч байсны нотолгоо мөн.

Эдүгээ Монгол төрийн албаны үүсэл, төлөвшил хөгжлийн бүх үе шатад хэлбэрэлтгүй баримтлагдаж ирсэн шударга ёс, хичээнгүйн соёл нь Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль, “Төрийн албаны тухай” Монгол Улсын хууль, төрийн тухай хууль тогтоомжийн бусад актуудад тусгагдан хэрэгжиж буй болно. Ер нь Монгол Улсад ардчилсан төрийн албаны төлөвшлийг 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн цаг үетэй холбон авч үздэг.

Монгол Улсын Үндсэн хуульд “... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх...” зорилтыг тунхаглан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь...” төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг тодорхойлон заасан. Үндсэн хууль, төрийн эрх мэдлийг хуваарилах үзэл баримтлалын дагуу Монгол Улсын ардчилсан төрийн

байгуулал тогтолцоог бүрдүүлж Монгол Улсад хүний болон иргэний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан билээ.

Төрийн эрх мэдлийг харилцан хяналт тэнцвэртэйгээр хэрхэн хуваарилахаас, тодруулж хэлбэл, засаглалын институци, тэдний бүрдэл хэсэг бүрийн төрийн албан хаагч нэг бүрийн үүрэг, эрхийг давхардал, хийдэлгүйгээр хэрхэн зөв хуваарилахаас төрийн албаны ажил хэрэг, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт шууд хамаарч байдаг.

Ардчилсан тогтолцооны үед эрх мэдлийн тулгуур эх сурвалж нь иргэд өөрсдөө байдаг. Тэдний хувьд Үндсэн хууль өөртөө нийгмийн гэрээг агуулдаг гэж үздэг бөгөөд эргээд иргэдийн дэмжлэгийн хариуд тэдний сайн сайхны төлөө Засгийн газрын эрх мэдлийг зохих хэмжээнд хязгаарладаг. Энэхүү эрх мэдлийг хязгаарлах үзэл санааг “Үндсэн хуульт ёс” гэж томъёолдог.

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан “Төрийн албаны тухай” Монгол Улсын хууль (1994)-д “төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ” гэж тодорхойлон заагаад шударга ёс, хууль дээдлэх ёс, ардчилсан, нээлтэй, ил тод байх зарчмуудыг төрийн албанд баримтлах үндсэн зарчим болохыг баталгаажуулсан.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш төрийн албаны төлөвшил хөгжил нь манай оронд өрнөж эхэлсэн улс төрийн болон эдийн засаг, нийгмийн асар их өөрчлөлтийн тусгал болж, тодорхой үе шатуудыг дамжин хэрэгжиж ирлээ.

Шинэтгэлийн эхний үе шатанд Монгол Улс төрийн байгууллынхаа шинэ бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, засаглалын хуваарь, зааг хүрээг тогтоох, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэхийг, хоёр дахь үед нь төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэшсэн төрийн албаны тогтолцоог бий болгох, түүний эрх зүйн орчныг бүрдүүлэхийг гол зорилт болгон түүнийгээ хэрэгжүүлж иржээ. Энэ үеийн гол зорилго нь 2004 онд УИХ-аас батлан гаргасан төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн зорилтуудаар тодорхойлогдож байна. Энэхүү баримт бичигт заахдаа Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго нь: иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино гэсэн буй.

Шинэтгэлийн гурав дахь үе шат 2017 онд батлагдаж, 2019 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга) хуулийн хэрэгжилтээр тодорхойлогдож буй хэмээн хэлж болно.

Энэхүү шинэчлэн найруулсан хуульд төрийн албаны эрхэм зорилгыг анхлан хуульчлан тодорхойлсон юм. Үүнд:

“Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино” хэмээн тодотгон томъёолсон. Энэ нь монгол төр эрхэмсэг оршихуйн үндэс болсоор ирсэн шударга ёс, хичээнгүйн соёлын үзэл санаа, үндсэн зарчмыг орчин үеийн ойлголтоор илэрхийлсэн хэлбэр юм. Тухайлбал, “... Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж” гэдэг нь хууль дээдлэх ёсон буюу шударга ёсны зарчим мөн. Жирийн иргэн, төрийн жирийн албан хаагч, улс төрийн өндөр албан хаагч аль алинд нь хууль адил тэгш үйлчилж, хуулийн хариуцлага нь ижил тэгш байвал сая шударга ёс болно. “... ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх...” нь төрт ёсны хичээнгүйн соёлын илэрхийлэл болой.

Шударга ёс, хичээнгүйн соёлын үзэл санаа, өв уламжлал нь өнөөгийн төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагт тусгалаа олсон юм. Иргэн хүн төрийн албан тушаалд анх орохдоо “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая” хэмээн тангараг өргөдөг. Энэ нь төрийн алба бол эрхэм чухал, нэр төрийн хэрэг алба болохыг иргэнд ухааруулан сануулж буй хэлбэр юм.

46

Энэ тангаргаа цаг ямагт санан сахиж, төв шударгуу ёсыг баримталж, ажил албандаа чин сэтгэлээсээ хандаж байгаа төрийн албан хаагчдыг иргэд олон түмэн мэддэг, хүндэтгэж ханддаг юм.

Төрөө дээдлэх үзэл хандлагын эх үндэс нь эндээс улбаатай. Төрийн түшмэд, албан хаагчид л олныхоо итгэл хүндлэлийг хүлээж шударгуу хичээнгүй зүтгэлийн үлгэр дуурайллын үзүүлж байвал иргэд олон түмэн төрөө хүндэтгэж, төрөө түшин эвлэлдэн нэгддэг нь түүхээс тодорхой харагддаг. Тийм ч учраас чин шударга, хичээнгүй зүтгэлт, олны илтгэл хүлээсэн төрийн албаны түшмэл, төрийн зүтгэлтэн, удирдагчаа “төрийн түшмэл эрдэнэ” хэмээн хүндэтгэн өргөмжилж ирсэн бахархам сайхан уламжлал бидэнд бий. Хаант төрийн үед “төрийн долоон эрдэнийн нэг нь түшмэл эрдэнэ” хэмээн өргөмжилдөг байсан бол ардын төрийн үед ч энэ уламжлал хадгалагдсаар ирсэн.

Төрт ёсны түүхэнд Шихихутуг, Елюй Чу-Цай, Чингай нараас эхлээд Ж.Цэвээн, хичээнгүй сайд Б.Цэрэндорж, Агданбуугийн Амар, Магсар Хурц, Сангийн сайд С.Довчин, Ж.Самбуу, Д.Моломжамц, Б.Чимид гээд төрийн олон тулхтай зүтгэлтнүүд он удаан жил төрд зүтгэсэн байдаг.

Үүний нэгхэн жишээ нь саяхан 130 жилийн ойг нь ёслол тэмдэглэсэн, “Монгол төрийн мэргэн өвөө” хэмээн түмэн олондоо хүндлэгдсэн Жамсрангийн Самбуу гуайн амьдрал түүх юм. Ж.Самбуу гуай хошуу тамгын хавсраа (туслах) бичээчээс эхлэн яамны туслах түшмэл, ахлах түшмэл, хэлтсийн дарга зэрэг эрхэлсэн түшмэл, газрын дарга, орлогч сайд буюу тэргүүн түшмэл, аймгийн шүүхийн дарга, аймгийн засаг дарга зэрэг төрийн захиргаа болон улс төрийн алба, гадаад улсад Монгол Улсаа төлөөлөн суух онц

бөгөөд бүрэн эрхт элчин сайд зэрэг дипломат албыг шат дараалан хашиж төрийн жинхэнэ шударга, хичээнгүй, төлөв даруу чухам эрдэнэ мэт түшмэл буюу албан хаагч гэдгээ ажил амьдралаараа батлан харуулсан байдаг.

Ийнхүү олон түмний итгэл хүлээж, тэдэндээ хүндлэгдэх болсон учраас Ж.Самбуу гуай Ардын Их Хурлын депутатаар 7 удаа дараалан сонгогдож, 21 жил хууль тогтоох дээд байгууллагад ажилласны 18 жилд нь АИХ-ын Тэргүүлэгчдийн даргын өндөр дээд албан тушаалыг нэр төртэй хашиж, төрийн тамгыг түшсэн гайхалтай, бахархам түүхтэй төрийн жинхэнэ хар хүн, төрийн зүтгэлтэн хүн байжээ. Түүний энэхүү хүндлэгдэн дээдлэгдэхийн үндэс нь төрийн хүний шударга ёс, хичээнгүй зүтгэл, төр ёсны эрхэм соёл, ёс суртахуун нь байсан юм. “Сайн төрийн тэргүүнд шударга түшмэл” гэдэг энэ буюу. Эрдэм чадал, хичээл зүтгэл, төв шударга ёс, гавьяа зүтгэлээрээ шалгарч төрийн албыг шатлан дэвшиж хашдаг энэ уламжлалыг шинэчилсэн хуульд оруулж суулгасан юм. Энэ бол чадахуйн зарчим буюу мерит зарчимд суурилсан шатлан дэвших тогтолцоо юм.

#### 4.Дүгнэлт

Монгол төр, бодлого үйл ажиллагааны нэр хүнд нөлөө нь төр түмнийг холбох гүүр нь болсон эрхэм түшээ, түшмэд, алба хаагч нарын үнэнч шударга, соёлтой хичээл зүтгэл, эрдэм боловсрол, ур чадвар, хүний мөс жудгаас үлэмж хамааралтайг онцолж байна. Шударга бусад чанга хатуу, эгэл түмэндээ ээлтэй, ам ажил нь яв цав нийлдэг байх нь төрийн хүний ажил үйлс бүтээмжтэй байж монгол төр эрхэмсэг оршихуйн үндэс нь болно. Ажил хэргээ мэддэг, ур чадвар сайтай, шударга хичээнгүй төрийн албан хаагчийг төлөвшүүлэхэд манай өвөг дээдэс ахмад үеийнхний маань төр барих, залахуйн арга ухаан, туршлага сургамж үлэмж үнэ цэнтэй хэвээр байна.

#### 5.Эх сурвалж

- *Иргэний хууль, 2002 он.*
- *Нотариатын тухай хууль, 2011 он.*
- *Beurkundungsgesetz, Germany, 1969.*
- *Dini Sasmitaningrum, Hanif Nur Widhiyanti, Erna Anggriani. (2025) “Legal Protection for consumer buyers of flats with a sale and purchase agreement made under hand through the pre project selling system,, Legal Horizons, Vol. 26, No.3, 62. <https://doi.org/10.54477/LH.25192353.2025.3.pp.60-67>*
- *German Civil Code (BGB), 1896*
- *Hans Ola Jingryd. (2013), Legal counsel in European real estate conveyances:Brokers and Notaries, ERES Working Paper series, European Real Estate Society, 4. <https://shuukh.mn/>*